

**ОЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ
БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022 оны 04 дүгээр
сарын 06-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөл санаачлагч нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар зохион байгуулагдаж байгаа “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд ойн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны эрх зүйн орчныг бүрдүүлэх, ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх талаарх хууль тогтоомжийг сайжруулах, төр, хувийн хэвшлийн уялдаа холбоог хангах, иргэн, хуулийн этгээдийн ойн үйл ажиллагаа эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, урамшуулах, ойн аж ахуйг бүсчлэн хөгжүүлэх, модлог ургамлын үр, үржлийн материал бэлтгэх, сайн чанарын үрээр ойн үрийн нөөц сан бүрдүүлэх, орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэх, төсөв, санхүү, хандивын хөрөнгийг төвлөрүүлэх, зарцуулахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох зорилгоор Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулжээ.

Байнгын хорооны хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээхэд ойн асуудал хариуцсан орон нутгийн байгууллагууд, нөхөрлөл хоршоо хэрхэн ажиллаж байгаа, ойн цэвэрлэгээнээс гарах модыг эргэж ашиглах боломж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан шинээр байгуулагдах ойн газрын бүтэц зохион байгуулалтын талаар, ойг ашиглах, нөхөн сэргээх, эдийн засгийн эргэлтэд оруулахад хөрөнгө, санхүүгийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх, хүний нөөц, мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг тэрбум мод тарих арга хэмжээний хөтөлбөртэй холбоотойгоор иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулахад ямар арга хэмжээ авах, хортон шавжтай тэмцэх тооцоо судалгааны талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын төсөвт ойн газар байгуулагдах санхүүжилтийн талаар, ойн сангийн талбайг нэмэгдүүлэх талаар хуулийн төсөлд хангалттай тусгагдсан эсэх, иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах арга хэмжээний талаар, Улсын Их Хурлын гишүүн Т.Энхтүвшин Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай хэрхэн нийцүүлсэн талаар, мод үржүүлгийн тарьц суулгацын нөөц, усалгааны асуудлаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Өнөрболор “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн нь газар тариалангийн нэгдсэн бодлоготой хэрхэн уялдсан талаар, Улсын Их Хурлын гишүүн

О.Цогтгэрэл тэрбум мод тарихад эдийн засгийн үр өгөөжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд хуулийн төсөлд тусгагдсан ойн газрын бүтэц зохион байгуулалт, хэрэгжүүлэх арга хэмжээ хангалтгүй тул хуулийн төслийг буцаах, бүсийн ой аж ахуй байгуулах талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Х.Болорчулуун хуулийн төслийг чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхтэй холбогдуулан Байнгын хорооны тогтоолоор ажлын хэсэг байгуулж ажиллах, мод тарих арга хэмжээний хүрээнд урамшууллын тогтцолцоог тодорхой болгох, тарьсан модоо хаягжуулах, арчилж хамгаалах, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал бүсийн ойн мөнөжмөнтийн асуудлыг ойн мөнөжмөнтийн төлөвлөгөөнд тодорхой тусгах, ойн газрын бүтэц орон тооны асуудал Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуультай нийцээгүй, мод үржүүлэг, тарьц суулгацын ажлыг хувийн хэвшлээр, мэргэжлийн удирдлагыг агентлаг хариуцах, мод тарих байршил, орчин нөхцөлийг тодорхой болгох, иргэдийн амжиргааг сайжруулахад жимсний модыг түлхүү тариалах, эдийн засгийн эргэлтэд оруулах, ажлын байр бий болгох, ой модыг нөхөн сэргээхтэй холбогдуулан мод бэлтгэлийн ажлыг дараа жилийн мод бэлтгэх ажилтай уялдуулах, Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ төрийн байгууллагыг өргөжүүлэхээс илүү мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд анхаарах, мөнөжмөнтийн төлөвлөгөөг сайжруулах, аймаг, орон нутгийн иргэд, ойн нөхөрлөлтэй хамтарч ажиллах, ойг ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхэд ялангуяа хуш модоо хамгаалахад түлхүү анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Б.Бөйсөн мод тарихад усжуулалтын асуудалд анхаарах, хуулийн төсөлд тусгагдсан бүсийн ойн аж ахуй байгуулах гэсэн зохицуулалтыг анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг хуулийн төслийн зүйл, заалтад анхаарч ажиллах, бүсийн аж ахуй байгуулах асуудалд анхаарах, ойн газар нь усны газартай хамтарч ажиллах талаар бодлогын асуудлыг хуулийн төсөлд тусгах, Улсын Их Хурлын гишүүн Б.Саранчимэг хуулийн төсөлд тусгагдсан ойн сан, ойн талбайг нэмэгдүүлэхэд эрдэмтэн судлаачдын эдийн засгийн тооцоолол, судалгааг шинжлэх ухааны үндэслэлтэй гаргах, хортон шавжтай тэмцэхэд орчин үеийн техник, технологийг нэвтрүүлэх нь зүйтэй гэсэн саналыг хэлсэн болно.

Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг төслийн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮНС,
ХӨДӨӨ АЖ АХУЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**



Х.БОЛОРЧУЛУУН